



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/984

Мандалговь

“Ид шидийн орон” жишиг төвийн барилгын  
ажилд дэмжлэг үзүүлэх тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.16 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Лантуун дохио” төрийн бус байгууллагаас санаачлан хэрэгжүүлж буй хүүхэд хамгаалал, хөгжлийн “Ид шидийн орон” жишиг төвийн барилгын ажлын гадна шугам сүлжээ, гадна цахилгаан хангамжийн ажилд орон нутгаас 55,400.000 (Тавин таван сая дөрвөн зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 55,400.000 (Тавин таван сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111006